

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын
2018 оны . . . дугаар сарын . . . ны/ий өдрийн . . .
дугаар тушаалын . . . дугаар хавсралт

МАЛ ЭМНЭЛГИЙН ГЭРЧИЛГЭЭ, ТҮҮНИЙГ ХЭРЭГЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг сум, дүүргийн нутаг дэвсгэрээс гадагш худалдаалах, төхөөрөх, олон нийтийг хамарсан арга хэмжээнд оролцуулах, хээлтүүлэгт ашиглах болон бусад зорилгоор шилжилт хөдөлгөөн хийх үед мал эмнэлэг, ариун цэвэр-гарал үүслийн гэрчилгээг /цаашид "мал эмнэлгийн гэрчилгээ" гэх/ хэвлүүлэх, хуваарилах, бичиж олгох, зарцуулах, бүртгэх, хяналт тавих, нэгдсэн мэдээлэлийн сан үүсгэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

1.2. Энэхүү журмыг мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий, эд бүтээгдэхүүнд мал эмнэлэг, ариун цэврийн баталгаажуулалт хийж гарал үүслийг тодорхойлох орон нутгийн мал эмнэлэг, үржлийн үйлчилгээний нэгж, түүний харьяа малын эмч, гарал үүслийг баталгаажуулах, хяналт тавих мал эмнэлгийн улсын байцаагч, Засаг дарга, иргэн, хуулийн этгээд дагаж мөрдөнө.

1.3. Иргэд хувийн хэрэгцээндээ зориулсан мах, сүү, сүүн бүтээгдэхүүнд энэхүү журам хамаарахгүй. *Хувийн хэрэгцээ гэдгийг орон нутгийн нийтийн зорчигч тээврийн хэрэгсэлээр зорчин яваа зорчигч эсвэл тухайн тээврийн хэрэгсэлээр яваа зорчигч тус бүрт хамаарах нэгээс дээшгүй тооны гулууз мах, махан бүтээгдэхүүн, арьс шир, литрээс дээшгүй хэмжээтэй сүү, сүүн бүтээгдэхүүн, 30 ширхэгээс ихгүй өндөг гэж ойлгоно*

Хоёр. Мал эмнэлгийн гэрчилгээний төрөл, олгох, хэрэглэх

2.1. Малын эрүүл мэнд, гарал үүслийн баталгаажуулалтын мал эмнэлгийн гэрчилгээ нь дотоодод “мал эмнэлгийн гэрчилгээ”, олон улсын худалдаанд “олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ” байна.

2.2. Дотоодын мал эмнэлгийн гэрчилгээг гэрээт мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн ирүүлсэн тодорхойлолтыг үндэслэн эрүүл мэндийн шаардлага хангасан, гарал үүсэл нь тодорхой мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд мал эмнэлгийн улсын байцаагч олгоно.

2.3. Мал эмнэлгийн мэргэжлийн байгууллагын олгосон мал эмнэлгийн гэрчилгээг зөвхөн эрүүл мал, амьтан, мал эмнэлэг- ариун цэврийн шаардлага хангасан түүхий эд, бүтээгдэхүүний баталгаажуулалт, гарал үүслийг тодорхойлох зорилгоор хуульд заасны дагуу хэрэглэнэ.

2.4. Мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг сум, дүүргийн нутаг дэвсгэрээс гадагш чиглэсэн тохиолдлууд худалдаалах, төхөөрөх, олон нийтийг хамарсан арга хэмжээнд оролцуулах, хээлтүүлэгт ашиглах болон бусад зорилгоор шилжилт хөдөлгөөн хийх үед заавал мал эмнэлгийн гэрчилгээ авна.

2.5. Гэрээт мал эмнэлгийн нэгжийн малын эрүүл мэндийн тодорхойлолт, “мал эмнэлгийн гэрчилгээ” болон “олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ”-ний загварыг Монгол улсын малын ерөнхий эмч батална.

2.6. Гэрчилгээний хуудас нь улсын хэмжээнд нэгдсэн кодтой хэвлэмэл маягт байх ба тус бүр давтагдахгүй дугаартай байна.

Гурав. Мал эмнэлгийн гэрчилгээний бичилт, хэрэгжилтэд хяналт тавих

3.1. Орон нутгийн гэрээт мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн малын эмч мал, амьтны эрүүл мэнд, тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүний мал эмнэлэг, ариун цэврийн баталгаажилтын тодорхойлолт олгохдоо харьяалах нутаг дэвсгэрийнхээ малын эрүүл мэндийн нөхцөл байдал, малын халдварт, паразиттах өвчний голомтын судалгаа, мал эмнэлгийн үзлэг, мэдрэхүйн эрхтний болон шаардлагатай тохиолдолд лабортаорийн шинжилгээний дүнг үндэслэнэ.

3.2. Мал эмнэлгийн улсын байцаагч нь мал эмнэлгийн гэрчилгээг гэрээт мал эмнэлгийн үйлчилгээний нэгжээс ирүүлсэн тодорхойлолт хууль, журамд заасан шаардлагыг хангасан эсэхийг хянасны үндсэн дээр олгоно.

3.3. Мал эмнэлгийн гэрчилгээг олгохдоо бүртгэл хөтөлнө. Шаардлагатай тохиолдолд мал, амьтан, түүхий эд бүтээгдэхүүнд лабораторийн нарийвчилсан шинжилгээ хийлгэж шинжилгээний дүнг үндэслэн гэрчилгээ олгоно.

3.4. Мал эмнэлгийн хорио цээрийн хяналтын цэгт ажиллаж байгаа болон сум дүүргийн мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч нь мал эмнэлгийн гэрчилгээ аваагүй мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг хорио цээрийн хяналтанд оруулж хуулийн дагуу арга хэмжээг хэрэгжүүлнэ.

3.5. Монгол Улсын хилээр нэвтрүүлэх мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн нь эрүүл мэндийн болон эрүүл ахуй, ариун цэврийн нөхцөл, шаардлагыг хангасан эсэхийг улсын хэмжээнд мал эмнэлгийн салбарын ерөнхий байцаагч, аймаг, нийслэлд салбарын ерөнхий байцаагчийн зөвшөөрснөөр мал эмнэлгийн улсын ахлах байцаагч, улсын байцаагч баталгаажуулан олон улсын мал эмнэлгийн гэрчилгээ олгоно.

5.4. Мал эмнэлгийн гэрчилгээ олгогдож шилжилт, хөдөлгөөн хийгдсэн мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний төрөл, тоо хэмжээний талаарх мэдээллийг мал эмнэлгийн анхан шатны байгууллага холбогдох дээд шатны байгууллагад сар бүр мэдээлнэ.

5.5. Мал эмнэлгийн гэрчилгээний зарцуулалтын тайлан, үзлэг, шинжилгээнд хамрагдсан мал амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний талаархи мэдээллийн маягын загварыг Хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

5.6. Мал эмнэлгийн гэрчилгээний бичилт, зарцуулалтад бүх шатны мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч нар хяналт тавина.

5.7. Монгол улсын малын ерөнхий эмчийн баталснаас бусад мал эмнэлгийн гэрчилгээг хүчингүйд тооцно.

5.8. Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж, мал эмнэлгийн улсын байцаагч энэхүү журамд заасан болон гэрчилгээнд бичсэн үндэслэлээс өөрөөр гэрчилгээ олгохыг хориглоно.

Зургаа. Иргэн, хуулийн этгээдийн эрх, үүрэг

6.1. Мал, амьтан тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг тээвэрлэлтийн явцад замын хяналт, шалгалтын цэгт шалгуулж мал эмнэлгийн гэрчилгээнд хяналт, шалгалт хийлгэсэн тухай тэмдэглүүлнэ.

6.2. Орон нутгаас олгосон гэрчилгээг дахин ашиглах, засварлах, хуурамчаар үйлдэхийг хориглоно.

6.3. Гэрчилгээ олгохтой холбогдсон асуудлаар холбогдох дээд шатны байгууллагад гомдол гаргах эрхтэй.

Хавсралт 1: Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжээс ирүүлсэн тодорхойлолт

Тодорхойлолт	Гийм/ үгүй	Тайлбар
Халдварт өвчингүй, тайван бүс, нутагт маллаж байсан эсэх;		
Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх шаардлагатай дархлаажуулалтад хамрагдсан эсэх		
Тухайн мал, амьтанд халдварт өвчний ерөнхий болон өвөрмөц шинж тэмдэг илэрсэн эсэх		
Хүнсэнд хэрэглэх мал, амьтанд эм хэрэглэснээс хойших хориглох хугацаа өнгөрсөн эсэх;		
Хуульд заасны дагуу ялган тэмдэглэгээ, бүртгэл хийгдсэн эсэх.		

Хавсралт 2: Дотоодын мал эмнэлгийн гэрчилгээний загвар

Мэдээлэл	Тайлбар
Тодорхойлолт гаргасан гэрээт эмчийн нэр, огноо	
Мал эмнэлгийн улсын байцаагчийн нэр (код), огноо	
Мал эмнэлгийн гэрчилгээний дугаар	
Амьд, мал амьтны мэдээлэл (төрөл, нас, хүйс, ээмэгний дугаар г.м)	
Мал, амьтны гаралтай түүхий эд бүтээгдэхүүний мэдээлэл (төрөл, тоо, хэмжээ)	
Мал эмнэлгийн гэрчилгээний хүчинтэй хугацаа	
Бэлчээрийн төлвийн мэдээлэл	
Гарал үүсэл: улс, аймаг, сум, баг, малчны нэр	
Тээвэрлэх маршрутын мэдээлэл	
Тээвэрлэж/ хариуцаж буй хүний мэдээлэл, холбоо барих хаяг	
Эцсийн хүрэх газрын нэр	
Давтагдахгүй буюу хуурамчаар хийхээс сэргийлсэн код	

Хавсралт 3: Олон улсын мал эмнэлгийн гэрчилгээний загвар

Мэдээлэл	Тайлбар
Тодорхойлолт гаргасан гэрээт эмчийн нэр, огноо	
Мал эмнэлгийн улсын байцаагчийн нэр (код), огноо	
Мал эмнэлгийн гэрчилгээний дугаар	
Амьд, мал амьтны мэдээлэл (төрөл, нас, хүйс, ээмэгний дугаар г.м)	
Мал, амьтны гаралтай түүхий эд бүтээгдэхүүний мэдээлэл (төрөл, тоо, хэмжээ)	
Мал эмнэлгийн гэрчилгээний хүчинтэй хугацаа	
Бэлчээрийн төлвийн мэдээлэл	
Гарал үүсэл: улс, аймаг, сум, баг, малчны нэр	
Тээвэрлэх маршрутын мэдээлэл	
Тээвэрлэж/ хариуцаж буй хүний мэдээлэл, холбоо барих хаяг	
Эцсийн хүрэх газрын нэр	
Давтагдахгүй буюу хуурамчаар хийхээс сэргийлсэн код	